



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хөрөнгө оруулалтыг төлөвлөх үйл явц хангалтгүй байгаагаас үр нөлөө, үр ашгийн тооцоо судалгаа хийгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.



Аудитын код: ГАГ-2020/02/-ГА

Сэдэв: “УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮН, ҮР АШИГ”

Цахим
хуудас:
www.audit.mn
Дорноговь
аймаг
2020 оны 04
сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор: Л.Равдандорж

Цахим хаяг: ravdandorj.l@audit.gov.mn

Агуулга	
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог.....	4
Дүрслэлийн товъёог	4
Хавсралтын товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	5-6
Бүлэг 1. А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг салбар болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан шат шатанд төлөвлөж байгаа ч үр ашгийг тооцож судлаагүй байна.	
А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан ч ТАХ-г ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.	7-8
А.1.1. Орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд нь дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.	8
А.1.2. Орон нутгийн саналд үндэслээгүй ТАХ-г салбарын Сайдын хөрөнгө оруулалтын төсөвт тусгасан байна.	8
А.1.3. УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэхгүйгээр ТЕЗ-дад хүргүүлсэн байна.	9
А.2. Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашиг, нийгмийн болон эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн байна.	
А.2.1. Батлагдсан төсөвт үндэслэн ТАХ-ний ажлын даалгаврыг боловсруулсан байна.	9
А.2.3. Зураг, төсөвт магадлалыг чанаргүй хийж байгаагаас ТАХ-г хэрэгжүүлэх явцад тооцоологдоогүй нөхцөл байдал үүссэн байна.	9-11
А.2.4. Төсвийн тухай хуулиар зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулагдаагүй ажлыг төлөвлөж батлуулсан байна.	11-12
А.2.5. Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хууль батлахаас өмнө гаргаагүй байна.	12
А.2.6. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг баталсан байна.	12-13
А.2.7. Хөрөнгө оруулалтын шинж чанартай ТАХ-үүдийг төлөвлөж, батлуулсан байна.	13
БҮЛЭГ 2. Б. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх боловсон хүчний хүртээмжгүй байдал нь УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанарт нөлөөлсөн байна.	
Б.1. Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа оролцогчийн тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласан, оролцогч оролцоогүй шалтгаанаар тендер олон удаа зарласнаас ТАХ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.	
Б.1.1. ТЕЗ-аас ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн байна.	13-14
Б.1.2. Хугацаа алдаж ХАА-г зарласнаас зарим ТАХ чанаргүй хийгдэх нөхцөл үүссэн байна.	14-15
Б.1.3. Зарим тендерийн баримт бичгийг хууль, журмын шаардлагад нийцүүлээгүй, тухайн ТАХ-ний онцлогт тохируулж боловсруулаагүй байна.	15-16
Б.1.4. Тендерт оролцож байгаа оролцогч компаниудын ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг хязгаарласан байна.	16-17
Б.1.5. ХАА-ны 2019 оны хагас болон жилийн эцсийн тайланг журамд заасан хугацаанд бэлтгэж хүргүүлсэн байна.	17

	Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй байна. Б.2.1. Захиалагч гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна. 18-19 Б.2.2. Мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан захиалагчийн хяналтыг чанартай, бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна. 19-21 Б.2.3. Шинэ хөдөө төслийн хүрээнд барилга, байгууламж барих төсөл арга хэмжээнд батлагдсан хөрөнгийн санхүүжилтийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна. 21-22 Б.3. Захиалагч, зохиогчийн хяналтын үр дүнг баримтжуулах, тайлагнах байдал хангалтгүй, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. Б.3.1. Захиалагч болон зохиогч үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг хянахгүйгээр зардлыг санхүүжүүлсэн байна. 22-24 Б.3.2. Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна. 24-25 Б.3.3. Аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА нь хуульд заасан дотоод хяналт хийх чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. 25 Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоогүй байна. Б.4.2 Зарим ТАХ-ний тухайн жилд батлагдсан санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэхгүй олгосон байна. 26 Б.4.3. 2019 онд ашиглалтад орсон 1057,6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаагүй байна. 27 Аудитын дүгнэлт.....28-29 Аудитын зөвлөмж.....30-31 Холбогдох байгууллагын санал.....32-35 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар.....36 Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай тушаал.....37-38 Хавсралт-1, 2.....39-40
--	---

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их хурал
СЯ	Сангийн яам
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БСШУСС	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ТАГ	Төрийн аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗГ	Засгийн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЗАА	Захирагчийн ажлын алба
НА	Нийцлийн аудит
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХААХХ	Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТББ	Тендерийн баримт бичиг
ТББ	Төрийн бус байгууллага
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
УКД	Улсын комиссын дугаар
УТ	Улсын төсөв
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Хүснэгтийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ТЕЗ-даас эрх шилжүүлэн хийгдсэн ТАХ-ний судалгаа	
Хүснэгт 2	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойш хугацаанд зураг, төсөвт магадлал хийлгэсэн ТАХ-ний судалгаа	
Хүснэгт 3	2019-2020 онд шилжин хийгдэх ТАХ-ний судалгаа	
Хүснэгт 4	ТЕЗ-даас ТАХ-г хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн хугацааны судалгаа	
Хүснэгт 5	2019 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилтийн гүйцэтгэлийн судалгаа	

Дүрслэлийн товъёог-1:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш хугацаанд газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгосон ТАХ	

Дүрслэлийн товъёог-2:

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2019 онд хэрэгжүүлэх ТАХ-ний төрөл	
График 2	Сумдад хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэл	
График 3	Төсвийн тухай хуулиар батлагдсан ТАХ-ний тоо	

Хавсралтын товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	ТАХ-г орон нутгийн дунд хугацааны бодлоготой уялдуулсан байдал	
Хавсралт 2	МУ-ын Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш зураг, төсөв боловсруулагдсан ТАХ-ний судалгаа	
Хавсралт 3		

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т гүйцэтгэлийн аудит хийнэ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. */Асуудлын шинжилгээг хавсралт 2-т үзүүлэв/*

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх;

**Аудитын хамрах
хүрээ**

Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд ТЕЗ-аас эрх шилжүүлж хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга, ЗДТГазар, Орон нутгийн өмчийн алба, ГХБХБГазар, Замын Үүд сумын ЗАА, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч компаниуд, ашиглагч байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

**Аудитын
хязгаарлалт**

"Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" сэдэвт гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөг ҮАГ-аас орон нутаг дахь Төрийн аудитын газруудад Able программаар 2020.02.20-ны өдөр ирүүлсэн байна.

Дорноговь аймаг дахь ТАГ-ын гүйцэтгэл болон нийцлийн аудитын багийн гишүүд 2020.02.28-ыг хүртэл хугацаанд санхүүгийн аудит гүйцэтгэсэн, мөн НАА-ын ахлах аудитор нь 2020.03.02-ыг хүртэл хугацаанд давхар аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэж байсан зэрэг ажиллах хүчний хүрэлцээгүй байдлаас шалтгаалан тус гүйцэтгэлийн аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг 2020.03.11-ний өдөр батлуулж, аудитыг эхлүүлсэн болно.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллагын улсын төсвөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүй, нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан болно.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Л.Равдандорж нар гүйцэтгэв.

Аудитын тайлан, судалгааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, дарга, тэргүүлэх аудиторовын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/14 тушаалаар баталгаажуулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

- Аудитыг гүйцэтгэх хугацаа богино, хамрах хүрээ их, хүний нөөцийн дутагдалтай байдал зэрэг нь аудит гүйцэтгэх хугацаанд нөлөөллөө.
- COVID-19 өвчлөлийн улмаас сумдад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэл, ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзэх боломжгүй болж, холбогдох ажилтнуудтай утсаар мэдээлэл солилцон, тайлбар тодруулга авч, хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийн зургийг цахимаар авч ажиллалаа.

БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг салбарын болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан шат шатанд төлөвлөж байгаа ч үр ашгийг тооцож судлаагүй байна.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан ч ТАХ-г ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийг Улсын их хурлаар 2018.11.02-ны өдөр баталсан бөгөөд тус хуулийн 2 дугаар хавсралтад Дорноговь аймагт улсын төсвийн хөрөнгөөр 83,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 35,9 тэрбум төгрөгийг тухайн онд санхүүжүүлэхээр баталжээ.


Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний 9 нь өмнөх оноос шилжиж ирсэн, 43 төсөл арга хэмжээ нь шинээр эхлэх төсөл, арга хэмжээ байна.

Батлагдсан 52 төсөл, арга хэмжээний 48 ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг аймагт шилжүүлсэн байна.

Д/д	ТЕЗ-ийн нэр	Эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо	/Хүснэгт№1/	
			Нийт төсөвт өртөг /сая.төгрөг/	2019 онд санхүүжих дүн /сая.төгрөг/
1	ХНХСайд	2	3373.4	2373.4
2	БХБСайд	9	18049.7	6668.9
3	БСШУССайд	26	22577.4	13900.6
4	ЗТХСайд	2	6452.3	2415.9
5	ХХААХҮСайд	5	1216.0	1216.0
6	ЭМСайд	4	8712.4	2837.6
	Дүн	48	60381.2	29412.4

2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г төрлөөр нь авч үзвэл барилга байгууламж шинээр барих ажил 91,9 хувь, их засвар 7,7 хувь, ТЭЗҮ боловсруулах ажил 0,3 хувийг эзэлж байна.

/График№1/



Дорноговь аймагт УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан нийт ТАХ-ний 46,6 хувийг Сайншанд, 20 хувийг Замын Үүд, 8,7 хувийг Хатанбулаг, 8,3 хувийг Алтанширээ суманд, 16,4 хувийг бусад сумдад хэрэгжүүлсэн байна.

/График№2/



А.1.1. Орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд нь дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

МУ-ын Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төрөөс баримталж байгаа МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, МУ-ын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий арга хэмжээг тусгахаар хуульчилсан байна.

Дорноговь аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 52 ТАХ нь МУ-ын төсвийн 2018-2021 онд хөрөнгө оруулалтын хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/, Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан байна. /Хавсралт№1/

А.1.2. Орон нутгийн саналд үндэслээгүй ТАХ-г салбарын Сайдын хөрөнгө оруулалтын төсөвт тусгасан байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 29.1-т “Хөрөнгө оруулалтын төслийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч бэлтгэж үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 8.4.3-т заасан хугацаанд ирүүлнэ”, 29.3.3-т “Нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах” гэж заасан.

2019 онд аймгийн Засаг даргаас 97249.4 сая төгрөгийн 71 ТАХ-г хэрэгжүүлэх саналыг салбарын Сайдуудад хүргүүлснээс 71938,0 сая төгрөгийн 32 ТАХ дэмжигдсэн байна.

Харин салбарын Сайдууд төсвийн төслийг өргөн барихдаа аймгийн ТЕЗ-ийн санал, тухайн ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг үндэслэхгүйгээр 11750.9 сая төгрөгийн 20 ТАХ-г нэмж батлуулсан. Тухайлбал:

- ✓ Эрүүл мэндийн сайдын багц - 2
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын багц - 5
- ✓ Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын багц - 8
- ✓ Барилга хот байгуулалтын сайдын багц - 2
- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц - 1
- ✓ Сангийн сайдын багц - 1
- ✓ Шадар сайдын багц - 1

Орон нутгийн саналд үндэслээгүй, үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдоогүй, зураг төсөв нь мэргэжлийн байгууллагаар баталгаажаагүй ажлыг тусгаснаар барилгын ажлыг эхлүүлэхэд цаг хугацаа алдах, төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх нөхцөл үүссэн байна.

А.1.3. УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэхгүйгээр ТЕЗ-дад хүргүүлсэн байна.

МУ-ын Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогод нийцсэн, нийгмийн ач холбогдол, салбарын хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг харгалзан үзэж эрэмбэлэхээр заасан.

Дорноговь аймгийн 14 сумаас 2019 онд УТХО-аар хийгдэх ТАХ-ний төлөвлөгөөнд тусгуулахаар 91 арга хэмжээний саналыг ирүүлсэн байна.

Аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс сумдаас ирүүлсэн дээрх саналыг эрэмбэлэхгүйгээр 8 Сайдад 71 төсөл арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.

А.2. Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашиг, нийгмийн болон эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн байна.

А.2.1. Батлагдсан төсөвт үндэслэн ТАХ-ний ажлын даалгаврыг боловсруулсан байна.

Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл зохиох, магадлал хийх дүрмийн 2.7-д “Архитектор төлөвлөлтийн даалгавар болон зургийн даалгаварт үндэслэн барилга байгууламжийн байршил, загвар зургийг эрх бүхий хуулийн этгээд боловсруулна” гэж заасан.

Дорноговь аймгийн хэмжээнд УТХО-аар нийт 22 барилга, байгууламж шинээр барих ажил тусгагдсанаас захиалагчаас 16 ТАХ-ний зурагт ажлын даалгавар, ГХБХБГ-аас 18 ТАХ-ний зурагт архитекторын даалгавар боловсруулсан байна.

Зохиогчийн боловсруулсан зураг, төсөвт захиалагч хяналт тавиагүйгээс зарим зураг, төсөв ажлын даалгаврын дагуу боловсруулагдаагүй байна. Тухайлбал:

- Сайншанд сумын кинотеатрын барилгын ажлын даалгаврын онцгой нөхцөлд газар хөдлөлтийн 6 баллд тэсвэртэй байхаар заагдсан байхад зурагт 5 баллд тэсвэртэй байхаар,
- Айраг, Улаанбадрах, Хөвсгөл сумдад баригдах Соёл, спортын төвийн барилгын төсөв батлагдахдаа 200 хүний суудалтай байхаар батлагдсан байхад ажлын даалгаврыг боловсруулахдаа үзвэрийн танхим нь 250 хүний суудалтай байхаар тусгаж, зураг төсвийг зохиогч ТГТ ХХК нь төсөвт 150 хүний суудалтай, онцгой нөхцөлийн газар хөдлөлтийн 6 баллд тэсвэртэй байхаар заагдсан байхад 5 баллд тэсвэртэй байхаар,
- Эрдэнэ суманд баригдах 80 ортой дотуур байрны барилга, Замын Үүд, Эрдэнэ, Сайншанд сумдад спорт талбай барих ажлуудын зураг төсвийг ажлын даалгавар, архитектор төлөвлөлтийн даалгаварт үндэслэж боловсруулаагүй байна.

Аймгийн хэмжээнд хот байгуулалтын архитекторын асуудал хариуцсан мэргэжлийн боловсон хүчин байхгүй байгаагаас шалтгаалж ажлын даалгавар, архитектор төлөвлөлтийн даалгаврын боловсруулалт, түүний хэрэгжилтэд хяналт тавих байдал хангалтгүй байна.

А.2.3. Зураг, төсөвт магадлалыг чанаргүй хийж байгаагаас ТАХ-г хэрэгжүүлэх явцад тооцоологдоогүй нөхцөл байдал үүссэн байна.

МУ-ын Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5.1-т "Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийнэ", 5.2-т "Барилгын тухай хуулийн 10.1.1-т заасан болон 7-оос доош баллын бүсэд хамаарах тус хуулийн 10.1.2, 10.1.3-д заасан ангиллын барилга байгууламжийн зураг төсөлд захиалагчийн хүсэлтээр магадлал хийж болно" гэж заасан.

2019 онд УТХО-аар хэрэгжүүлсэн нийт 42 ТАХ нь МУ-ын Барилгын тухай хуулийн 25.2.2 дахь заалтад хамаарахгүй, бага, дунд зэргийн төвөгшилтэйд хамааралтай боловч ТАХ-үүдийг чанартай хэрэгжүүлэх зорилгоор захиалагчаас 13 барилга, байгууламж барих ажлын зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

Барилгын тухай хуулийн 25.5-д "Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ" гэж заасан байна. Гэтэл дараах барилга, байгууламжийн зураг, төсөвт өөрчлөлт орсон байхад өөрчлөлтийг тусгаж магадлалаар батлуулаагүй байна.

- Сайншанд суманд баригдсан 1000 суудалтай соёл, спортын төвийн барилгын ажлын зурагт гадна ханыг 100 мм-ийн XPS хөөсөнцөр дулаалга, 120 мм-ийн тоосгон хана, сайжруулсан шавардлага, 2 үе хар тосон түрхлэг хийхээр тусгасныг тоосгон хана хийхгүйгээр дулаалгын хөөсөнцөр хавтангийн зузааныг нэмэгдүүлэн өөрчилж гүйцэтгэсэн.
- Сайншанд суманд 320 суудалтай сургуулийн барилга барих ажлын зурагт ус, дулааны 3 шугамтай байхаар тусгагдсаныг 5 шугамтай болгож техникийн нөхцөл гаргуулан нэмэлт ажлуудыг хийсэн, төсөвт 17 хяналтын камер суурилуулах зардал тусгагдсан байхад зурагт 7 камер байрлуулахаар тусгасан байна.

Барилгын тухай хуулийн 25.4-т "Зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно" гэж заасан байхад ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, зөвшөөрөл олгосноос хойш хугацаанд дараах 6 ажлын зураг төсвийг магадлалаар баталгаажуулсан байна.

/Хүснэгт№2/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан огноо	Зураг, төсөв магадлалаар баталгаажсан огноо
1	Цэцэрлэгийн барилга /Дорноговь, Алтанширээ сум/	2019.07.02	2019.07.22
2	Цэцэрлэгийн барилга 150 /Дорноговь, Замын-Үүд сум/	2019.06.05	2019.07.22
3	Соёл, спорт цогцолборын барилга, 1000 суудал /Дорноговь, Сайншанд сум/	2019.05.17	2019.12.25
4	Соёл, спортын төвийн барилга, 200 суудал /Дорноговь, Улаанбадрах сум/	2019.06.04	2019.08.01
5	Соёл, спортын төвийн барилга, 200 суудал /Дорноговь, Хөвсгөл сум/	2019.06.27	2019.08.01
6	Спорт заалны барилга /Дорноговь, Өргөн сум/	2019.06.05	2019.07.22

Барилгын тухай хуулийн 25.2.3-т "Магадлалыг барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хийнэ" гэж заасан байхад эксперт дараах ТАХ-ний зураг төсөлд шаардлагатай материалыг үнэлэхгүйгээр магадлалын дүгнэлт гаргасан байна.

- Алтанширээ сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга, байгууламжийн ажлын зураг төсвийг Монкузбас ХХК 2018.09.13-д хийж, 2018.09.13-ны өдөр магадлалаар баталгаажуулсан байна. Гэтэл зураг зохиогч нь уст цэгийг зөв тогтоогоогүйгээс гүний худгийн байршил өөрчлөгдөж, тус ажил өнөөдрийг хүртэл дуусаагүй, үргэлжилж байна.
- Хатанбулаг сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга, байгууламжийн ажлын зураг, төсвийг Монкузбас ХХК 2018.08.22-ны өдөр хийж, магадлалаар 2018.10.08-ны өдөр баталгаажуулсан байна. Гэтэл зураг зохиогч нь уст цэгийг зөв тогтоогоогүйгээс тус ажил өнөөдрийг хүртэл дуусаагүй байна.
- Улаанбадрах сумын 200 хүний суудалтай соёл, спортын төвийн барилгын ажлын зураг 2015 онд хийгдсэн, тус хугацаанаас хойш барилга баригдах газарт олон улсын шилэн кабель, цэвэр усны шугамууд суурилуулсан зэрэг инженерийн дэд бүтэцтэй холбоотой асуудлаас шалтгаалж барилгын байршил өөрчлөгдсөн, цахилгааны техникийн нөхцөл гараагүй байхад /2019.09.08-ны өдөр хийгдсэн/ зураг, төсвийг 2019.08.01-ний өдөр магадлалаар баталгаажуулсан байна.

Хэрэгжүүлсэн ТАХ-ний зураг, төсвийг магадлалаар баталгаажуулж байгаа нь зохиогчийн хариуцлагагүй байдлаас үүсэх эрсдэлийг багасгах зорилготой боловч зарим зураг, төсвийн зохистой байдлыг үнэлэхгүйгээр баталгаажуулснаас үүссэн алдааг залруулахад экспертийн мэргэжлийн хариуцлага хүлээх үүрэг хэрэгжээгүй байна.

А.2.4. Төсвийн тухай хуулиар зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулагдаагүй ажлыг төлөвлөж батлуулсан байна.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд Дорноговь аймагт 52 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталж, 2019 онд 36 ТАХ шинээр хэрэгжихээс 20 ТАХ-ний зураг, 21 ТАХ-ний төсвийг хууль батлагдсан гарснаас хойш боловсруулсан. /Хавсралт-2/

Шинээр баригдах барилга байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, үр ашгийн тооцоо, нийгмийн шинж чанартай барилга байгууламжийн хувьд түүнийг барих зайлшгүй хэрэгцээ, шаардлага, судалгаа, тооцоо, батлагдсан зураг төсвийг үндэслэн төлөвлөхөөр хуульчилсан ч дараах ажлуудын ТЭЗҮ хийгдээгүй байна.

- ✓ Алтанширээ, Хатанбулаг, Даланжаргалан сумдад инженерийн нэгдсэн шугам сүлжээ барих ажилд нийт 10,5 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан боловч хариуцаж ажиллуулах хуулийн этгээд нь тодорхойгүй, үр ашгийн тооцоо болон цаашид гарах урсгал зардлын тооцоо судалгаа хийгээгүй,
- ✓ Айраг, Улаанбадрах, Хөвсгөл сумдад 200 хүний суудалтай соёл, спортын цогцолборын барилга барих нийт 3,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажил батлагдсан боловч тус сумдын хүн амын тоо, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг тооцож судлаагүй, цаашид гарах байр ашиглалт, ажиллах хүч зэргийг тооцоогүй нь орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхээр байна.
- ✓ Сайншанд суманд 1,4 тэрбум төгрөгөөр Кино театрын барилга баригдсан ч хариуцах эзэн тодорхойгүйгээс үйл ажиллагаа нь эхлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ЭЗ-ийн төлөвлөлт, төсөл, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод “Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, санхүүжүүлэх, аймгийн ОНТХО, ОНХС, замын сангийн хөрөнгөөр тухайн онд хэрэгжүүлэх ХО, ТАХ-г төлөвлөх, аймгийн ИТХ-аар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн үндсэн чиг үүргийг тусгасан байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ний сүүлийн 5 жилийн судалгаанаас харахад Дорноговь аймагт 2016 онд 9159,3 сая төгрөгийн ТАХ хэрэгжиж байсан бол 2020 онд 112370,6 сая төгрөг буюу хөрөнгө оруулалтын ажлын төсөв даруй 8,2 дахин өссөн үзүүлэлттэй байна.


Аймагт хэрэгжиж байгаа ТАХ-ний тоо жилээс жилд нэмэгдэж байгаатай холбоотой ТАХ-ний орон нутаг дахь хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, эрэмбэлэх, төлөвлөх асуудлууд орхигдож, холбогдох мэргэжилтэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг хянаж, санхүүжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

А.2.5. Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хууль батлахаас өмнө гаргаагүй байна.

УТХО-аар шинээр баригдах барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл гараагүй ажлуудыг төлөвлөж, батлуулсан байна.

МУ-ын Барилгын тухай хуульд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг Төсвийн тухай хууль батлуулахаас өмнө гаргуулсан байна гэж заасан.

Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш 9 ТАХ-ний газрын зөвшөөрөл, 14 ТАХ-ний техникийн нөхцөл олгогдсон байна.



Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгох үйл ажиллагаа нь хууль батлагдсанаас хойш хийгдсэнээс ТАХ-г төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх нөхцөл үүссэн байна.

Эрдэнэ суманд баригдсан 80 ортой дотуур байрны барилгыг 2013 онд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэн П.Төрбатад эзэмшүүлсэн газар дээр барьсан бөгөөд тус газрын асуудлыг өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй байна.

А.2.6. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг баталсан байна.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэхээр 48 ТАХ батлагдаж, 2019 онд хэрэгжүүлэх 14 барилга, байгууламж барих ажлын санхүүжилтийг 2020 онд үргэлжлүүлэн санхүүжүүлэхээр баталсан байна. Орон нутаг төсөл арга хэмжээг тухайн онд багтаан бүрэн дуусгахаар гэрээ байгуулан ашиглалтад хүлээж авах акт үйлдсэн боловч ажил бүрэн дуусаагүй байна.

/Хүснэгт №3/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих Хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа
1	Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга байгууламж /Дорноговь, Алтанширээ сум/	2019-2020	
2	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж /Дорноговь, Хатанбулаг сум/	2019-2020	
3	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам, сүлжээ, барилга байгууламж /Дорноговь, Даланжаргалан сум/	2019-2020	
4	Дотуур байрын барилга, 80 ор /Дорноговь, Эрдэнэ сум/	2019-2020	
5	Цэцэрлэгийн барилга /Дорноговь, Замын-Үүд сум/	2019-2020	

6	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дорноговь, Мандах сум/	2019-2020	2019.12.20
7	Кино театрын барилга /Дорноговь, Сайншанд сум/	2019-2020	2019.12.25
8	Соёл, спорт цогцолборын барилга, 1000 суудал /Дорноговь, Сайншанд сум/	2019-2020	
9	Соёл, спортын төвийн барилга /Дорноговь, Айраг сум/	2019-2020	2019.12.31
10	Соёл, спортын төвийн барилга, 200 суудал /Дорноговь, Улаанбадрах сум/	2019-2020	
11	Соёл, спортын төвийн барилга, 200 суудал /Дорноговь, Хөвсгөл сум/	2019-2020	
12	Спорт заалны барилга /Дорноговь, Өргөн сум/	2019-2020	2019.11.29
13	Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замаас Ханбаянзүрх чиглэлийн хатуу хучилттай авто зам, 6.85 км /Дорноговь, Сайншанд сум/	2019-2020	
14	Төрөх эмнэлэг, 50 ор /Сайншанд сум/	2019-2020	

А.2.7. Хөрөнгө оруулалтын шинж чанартай ТАХ-үүдийг төлөвлөж, батлуулсан байна.

МУ-ын 2019 оны Төсвийн тухай хуульд Дорноговь аймагт шинээр барилга байгууламж барих 33, их засварын 12, зураг төсөл боловсруулах 3, автозамын 2, барилгын өргөтгөлийн 2, нийт 52 ТАХ-г хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Батлагдсан ТАХ-үүд нь хөрөнгө оруулалтын шинж чанартай байна. /График№3/



БҮЛЭГ 2. Б. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх боловсон хүчний хүртээмжгүй байдал нь УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанарт нөлөөлсөн байна.

Б.1. Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа оролцогчийн тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласан, оролцогч оролцоогүй шалтгаанаар тендер олон удаа зарласнаас ТАХ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

Б.1.1. ТЕЗ-даас ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журмын 2.11-т “Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасан.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийг УИХ-аар 2018.11.02-ны өдөр баталж, ЗГ-ын 2019.01.30-ны өдрийн 46 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалтад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад өөрчлөлт оруулсан байна.

ТЕЗ-аас УТХО-аар 2019 онд шинээр хэрэгжүүлэх 40 ТАХ-ний эрхийг орон нутагт журамд заасан боломжтой хугацаанд шилжүүлсэн байна. Эрх шилжүүлсэн хугацааг авч үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт №4/

ТЕЗ-ийн нэр	ТАХ-ний тоо	Эрх шилжүүлсэн хугацаа		Төндөрийн урилга нийтэлсэн хугацаа		61-ээс дээш
		Хоног		Хоног		
		1-30	31-60	1-30	31-60	
ХНХС	1	1				
БХБС	7	7		5	2	
БСШУСС	23	23		3	16	4
ЗТХС	2	1	1	1		1
ХХААХҮС	5	4	1	4	1	
ЭМС	4	4		2	1	1
ДҮН	42	40	2	15	20	6

Дорноговь аймгийн Иххэт суманд баригдсан Ахмадын өргөөний барилгын ажлын эрх шилжүүлсэн тухай шийдвэрийг ХНХС-аас ирүүлээгүй байна.

ЗТХС-ын багцад батлагдсан Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих бүс нутгийн автозам хөгжүүлэх төслийн Сайншанд-Замын Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18,25 км хатуу хучилттай автозам барих ажлын эрхийг 2019.05.28-ны өдөр орон нутагт шилжүүлсэн байна.

Б.1.2. Хугацаа алдаж ХАА-г зарласнаас зарим ТАХ чанаргүй хийгдэх нөхцөл үүссэн байна.

МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу 2019 онд 42 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Эрх шилжиж ирснээс хойш 1 сарын дотор ХАА-г зарласан 15, 2 сарын дотор зарласан 18, 3 сарын дотор зарласан 3, 4 ба түүнээс дээш сарын дараа зарласан 8 ТАХ тус тус байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019.05.01-ний өдрийн хуралдаанаар 2019 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор ТАХ-ний ХАА-г яаралтай зохион байгуулж 2019.06.30 дотор гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж дуусгах шийдвэрийг ТЕЗ нарт даалгасан байхад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны явцаас хамаарч дараах ажлуудын ХАА-г хугацаа алдаж зарласан байна. Үүнд:

- ✓ Иххэт суманд баригдсан ахмадын өргөөний барилгын ажилд ХНХС-аас эрх шилжүүлсэн тухай шийдвэр ирүүлээгүй, тендерийг 2019.09.25-нд зарлаж, гэрээг 2019.11.04-ний өдөр байгуулсан.
- ✓ Мандах суманд баригдсан 100 ортой цэцэрлэгийн барилга барих ажлын ХАА-г 2019.05.30-ны өдөр зарлаж, гүйцэтгэгчтэй 2019.07.25-ны өдөр гэрээ байгуулсан.
- ✓ Хатанбулаг сумын Соёлын төвийн барилгын дээвэр, гадна, дотор засварын ажлын ХАА-г 2019.07.26, 2019.08.28-нд зарлан, оролцогч оролцоогүй шалтгаанаар хүчингүй болж, 2019.10.02-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.
- ✓ Замын Үүд суманд спорт талбай байгуулах ажлын ХАА-г 2019.06.02-ны өдөр зарлаж оролцогч оролцоогүй тул 2019.07.02-д дахин зарлаж 2019.09.09-ний өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.
- ✓ Сайншанд суманд спорт талбай байгуулах ажлын ХАА-г 2019.07.26-д зарлаж 2019.09.16-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.

- ✓ Эрдэнэ сумын спорт талбайн ажлын 2 дугаар багцын ажлын тендерийг 2019.05.22-ны өдөр зарлаж, гүйцэтгэгчтэй 2019.07.17-ны өдөр гэрээ байгуулсан байна.
- ✓ Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам ажлыг ЗТХС-аас 2019.05.28 өдөр эрх шилжүүлж, ХАА-г 2019.08.28-ны өдөр зарласан боловч оролцогчгүйн улмаас хүчингүй болж, 2019.11.15-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Дээрх ажлуудын зураг, төсөв ажлын тоо хэмжээ урьдчилан гараагүй байснаас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил төлөвлөсөн хугацаанаас хойшлогдсон байна.

Б.1.3. Зарим тендерийн баримт бичгийг хууль, журмын шаардлагад нийцүүлээгүй, тухайн ТАХ-ний онцлогт тохируулж боловсруулаагүй байна.

МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэж заасан.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас УТХО-аар эрх шилжиж ирсэн ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 42 ХАА-г зохион байгуулсан байна. Үүний 31 ТАХ нь НТШ-ын аргаар, харьцуулалтын аргаар 8, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох 3 ТАХ байна.

Үнэлгээний хорооны боловсруулсан зарим тендерийн баримт бичиг нь хууль, журмын шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал:

- ✓ ТББ-т заасан дотоодын давуу эрх тооцох шалгуурыг хангаж шалгарсан 18 аж ахуйн нэгж нь аймгийн ХХҮГ-тай ажиллах хүч авах гэрээ байгуулсан боловч 12 компани орон нутгаас ажиллах хүч аваагүй, захиалагч гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.
- ✓ ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлд “Гүйцэтгэгч нь ажлыг өөрийн хөрөнгөөр бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгсний дараа санхүүжилтийг олгоно” гэж заасан нь оролцогчийн оролцоог хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гэвч 11 ажлыг бүрэн дуусгаагүй байхад санхүүжилтийг олгосон байна.
- ✓ ТББ-т чанарын баталгаат хугацааг алдаатай тусгасан.
- ✓ Алтанширээ, Мандах суманд цэцэрлэгийн барилга барих ТАХ-г НТШ-аар сонгон шалгаруулахдаа ТББ-ийг харьцуулалтын аргын жишиг баримтаар боловсруулж зохион байгуулсан.
- ✓ Сайншанд суманд 50 ортой төрөх эмнэлгийн барилга барих ажлын ХАА-г зохион байгуулахдаа "Дорноговь аймгийн Сайншанд сумын 50 ортой эмнэлгийн барилга угсралтын үлдэгдэл ажил" гэж хуулийн нэршлийг өөрчилж зарласан.
- ✓ ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлд бараа ажил үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний гүйцэтгэлийн чанарын баталгааг 5 хувиар тооцохоор заасан. Гэтэл 29 ажлын, нийт 1.6 тэрбум төгрөгийн

чанарын баталгааны барьцааг байршуулаагүй байсан зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

- ✓ МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.1-т “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасан байхад 4 ТАХ-ний тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтлээгүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар ХАА-г зохион байгуулах тухай бүр үнэлгээний хороог томилсон байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшил, эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэн, ЗДТГ-ын ажилтныг оролцуулахаар заасан байдаг.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийн оролцоог хуульд заасан тоогоор бүрэн хамруулаагүй, 7 ТАХ-ний үнэлгээний хороонд 2 төлөөлөл, 31-д 1, 4 ТАХ-ний үнэлгээний хороонд төлөөлөл оролцуулаагүй байх ба нийт зарласан ХАА-ны 17 хувьд төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл ажилласан байна.

2019 онд байгуулагдсан үнэлгээний хороонд 3 төрийн бус байгууллагын, 1 иргэний төлөөлөл оролцсон бөгөөд Айсуй цагийн түүчээ ТББ 15, Итгэл сэтгэл хандлага ТББ 5, ХААХХолбоо 11, иргэний төлөөлөл 14 удаа тус тус оролцсон байна.

Үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэгдэж байгаа асуудалд хорооны гишүүд бие даасан байдлаар хандаж байгаа нь тодорхой бус, хурлын тэмдэглэлд гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг бүрэн тусгаагүй байна.

Үнэлгээний хороо нь УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний ТББ-ийг боловсруулахдаа хууль, журамд заасан чанарын баталгаат хугацааг буруу оруулсан, санхүүжилтийн хэт хатуу нөхцөлийг тусгасан, гэрээний тусгай нөхцөлд тусгах шаардлагатай мэдээллүүдийг тусгаагүй орхигдуулсан, зарим ажлын тендерийн урилгыг сонинд нийтлээгүй, тухайн ХАА-нд мөрдөгдөх жишиг баримтыг өөрчилсөн, УТХО-аар хийгдэх ТАХ-ний жагсаалтад тусгагдсан нэрийг өөрчилж тендер зарласан, он дамжин хэрэгжих ТАХ-ний хугацааг уялдуулж тусгаагүй зэрэг зөрчлүүдийг гаргасан байна.

Б.1.4. Тендерт оролцож байгаа оролцогч компаниудын ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг хязгаарласан байна.

Захиалагч тендерт оролцогчдыг ил тод, нээлттэй, тэгш өрсөлдөх боломжоор хангахын тулд ТББ-ийг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, санхүү, техникийн чадавхи, туршлагыг бодитоор үнэлэх боломжийг бүрдүүлж ажиллахаар хуульчилсан.

2019 онд УТХО-аар хийгдэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой тендерт оролцогчдоос Сангийн яаманд 3, ШӨХТГ-т 1 гомдол гаргасан, үүнээс 2 гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн байна.

- Замын-Үүд сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын дотор сантехник, гадна бохир усны шугамын их засварын ажлын тендерт оролцсон Чандмань бадрал ОНӨХХК-нийг санхүүгийн тайлан ирүүлээгүй шалтгаанаар шаардлага хангаагүй гэж

- татгалзан, тоног төхөөрөмжийн холбогдох баримт бичгийг ирүүлээгүй, ижил төстэй ажлын гэрээний дүнгийн нийлбэр нь шаардлага хангаагүй байсан Оточ буян ХХК-ийг шалгаруулсан шийдвэрийг Сангийн яамнаас хянаж, үндэслэлгүй гэж дүгнэсэн байна.
- Айраг суманд баригдах Соёл, спортын төвийн 200 хүний суудалтай барилгын ажлын тендерт оролцогчоос гомдол гаргаж, ТАХ-ний баталгаажсан зургийг ТББ-т болон цахим сайтад байршуулаагүй, он дамжин хэрэгжүүлэх ажлыг 2019 онд гүйцэтгэх, хуульд санхүүжилт олгохоор батлагдсан байхад өөрийн хөрөнгөөр бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгсний дараа санхүүжилтийг олгохоор ТББ-т тусгасан байдал нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газраас хууль зөрчсөн нь үндэслэлтэй гэж тогтоосон байна.
 - Мандах сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа зайлшгүй шаардах үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудыг дурдахдаа ачааны автомашин, шанагат экскаватор, зуурмаг зуурагч гэх мэт техник хэрэгслийг зааж өгсөн боловч гүйцэтгэгчээс ирүүлсэн техник, тоног төхөөрөмжийн жагсаалт шаардлага хангахгүй, машин, механизмын түрээсийн гэрээг хавсаргаагүй, дотоодын давуу эрх тооцох саналд ХХҮГ-тай ажиллах хүч авах гэрээ байгуулж ирүүлээгүй байхад давуу эрх тооцсон, Үнэлгээний хорооны нарийвчилсан үнэлгээнд дээрх асуудлуудыг тодорхой зааж өгсөн боловч шаардлага хангахгүй материал ирүүлсэн Мөнх хялмаа ХХК-ний ирүүлсэн тендерийг “Хамгийн сайн” гэж үнэлэн шалгаруулсан байна. Гэвч тус компани нь ажил гүйцэтгэх гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцалсан байна.

Үнэлгээний хороо нь УТХО-аар хэрэгжүүлэх ижил төстэй ТАХ-ний ТББ-ийн шалгууруудыг харилцан адилгүй боловсруулсан, гэрээний тусгай нөхцөлд санхүүжилтийн хэт хатуу нөхцөлийг тусгаснаас оролцогчийн оролцоог хязгаарласан, зарим ТАХ-ний оролцогчдоос ирүүлсэн тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу үнэлээгүй, ШӨХТГ-аас гомдол хянаж, ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2019 онд 42 ХАА зохион байгуулж, 21 тендерийн баримт бичгийн гэрээний тусгай нөхцөлд “Гүйцэтгэгч нь ажлыг өөрийн хөрөнгөөр бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгсний дараа санхүүжилтийг олгоно” гэж заасан нь оролцогчийн оролцоог хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гэвч зарим ажил гүйцэтгэх гэрээнд санхүүжилт олгохоор тусгаж, 11 ажлын санхүүжилтийг олгожээ.

Сайншанд, Замын Үүд сумдад хүүхдийн цэцэрлэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилгыг худалдан авах ТАХ-г төсөвт тусгуулж ХАА-г зохион байгуулсан нь оролцогчдын нээлттэй, тэгш өрсөлдөх боломжийг хязгаарлах нөхцөлийг үүсгэсэн байна.

Б.1.5. ХАА-ны 2019 оны хагас болон жилийн эцсийн тайланг журамд заасан хугацаанд бэлтгэж хүргүүлсэн байна.

Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жилд 2 удаа хүргүүлэхээр заасны дагуу 2019.07.22-ны өдрийн 1/521, 2019.12.11-ний өдрийн 2/2142 тоот албан бичгүүдээр хүргүүлсэн байна.

МУ-ын Сангийн сайдаас Дорноговь аймгийн ТЕЗ-ын багцын 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 90 оноо бүхий шалгуур үзүүлэлтээр үнэлж, 76 буюу “Маш сайн” гэж үнэлжээ.

ХАА-ны 2019 оны тайлангийн хэрэгжилтийн үнэлгээгээр ХАА-г цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлсэн байдал, тендер шалгаруулалтын талаар гаргасан гомдол шийдэгдсэн байдал нь хангалтгүй дүгнэгдсэн байна.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй байна.

Б.2.1. Захиалагч гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна.

МУ-ын Иргэний тухай хуулийн 350.1-т “Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх үүрэг хүлээж, захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх” гэж заасан.

Дорноговь аймагт хэрэгжих ТАХ-ний жагсаалтад нийт 52 ажил тусгагдаж, 48 ажлын эрх шилжиж ирснээс өмнө онд гэрээ хийгдсэн 6, тайлант хугацаанд шинээр 42 гэрээг байгуулсан байна. Эрх нь шилжиж ирсэн ажлаас 25 ажлын гэрээний хугацааг сунгасан бөгөөд үүний 14 ажлыг улсын комиссоор ашиглалтад хүлээн авч, 11 ТАХ дараа онд үргэлжлэн хэрэгжсэн байна.

Төсвийн тухай хуулиар 2020 онд дуусахаар батлагдсан ТАХ-үүдийг 2019 онд бүрэн дуусгах гэрээ байгуулж, улсын комиссоор хүлээн авсан акт үйлдсэн боловч ажил бүрэн дуусаагүй, хүйтний улиралд ажлыг гүйцэтгэсэн нь ажлын чанарт нөлөөлсөн байна. Тухайлбал:

- ✓ Мандах суманд 75 ортой цэцэрлэгийн барилга барих 874,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2019.07.29-2019.12.01-ний хугацаанд гүйцэтгүүлэхээр Өгөөмөрөн шанд ХХК-тай гэрээ байгуулж, 2019.12.20-ны УКД-94/2019 актаар ажлыг хүлээж авсан боловч гадна фасад, гадна тохижилт, тоглоомын талбай, ногоон байгууламжийн ажлууд хийгдээгүй, ашиглалтын явцад халаалтын болон нөөц тогоо цоорсон байхад барилгын ажлыг ашиглалтад оруулах комиссын хурлаар тус ажлуудыг дулааны улиралд дуусгуулахаар шийдвэрлэсэн байна.
- ✓ Өргөн суманд спорт заалны барилга барих 900,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2019.06.15-2019.10.15-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр Баян дөрвөлж ХХК-тай гэрээг байгуулж, 2019.11.29-ний УКД-83/2019 актаар ажлыг хүлээж авсан боловч гадна дулаан хангамж, дотор салхивчны ажлууд хийгдээгүй байна.
- ✓ Айраг суманд 200 хүний суудалтай соёл спортын төвийн барилга барих 900,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2019.06.15-2019.12.15-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр Элит конкрет ХХК-тай гэрээг байгуулж, 2019.12.31-ний УКД-102/2019 актаар ажлыг хүлээж авсан боловч гадна засал, тохижилтын ажлуудыг хийгээгүй байна.
- ✓ Эрдэнэ суманд 80 ортой дотуур байр барих 1148,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2019.05.01-2019.08.20-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр ТОБЭМ ХХК-тай гэрээ байгуулан, 2020.02.25-ны УКД-08/2020 ажлыг хүлээж авсан боловч гадна тохижилт, явган зам, ногоон байгууламжийн ажлууд хийгдээгүй байна.

Дээрх дутуу хийгдсэн ажлуудыг бүрэн хийж дуусгуулахаар албан шаардлага хүргүүлээ.

Зураг, төсөл боловсруулах 36 ажлыг гүйцэтгүүлэхээр зохиогчтой гэрээ байгуулсан байна. Үүний 8 ажлын зургийг хүлээлгэж өгсөн хугацаа тодорхойгүй, 11 ТАХ-ний зургийн гэрээний хугацааг хэтрүүлсэн, 1 ТАХ-ний зургийг барилгын ажлыг дуусгасан өдөр

хүлээлгэж өгсөн нь зураг, төсөв зохиох гэрээний 4.2 дахь заалтыг зөрчсөн, захиалагч гэрээний биелэлтийг хангуулах талаар хяналт тавьж ажиллаагүй байна.

Тайлант онд 1 компани 2-5 ажлыг зэрэг гүйцэтгэхээр гэрээ байгуулж ажилласнаас гэрээний хугацаа сунгагдаж, зарим ажлууд чанаргүй хийгдсэн байна.

Монкузбасс ХХК	Буянт Ас ХХК	Эхний эхэн ХХК
1.Хатанбулаг 2019/5/7-2019/5/27, 2. Хөвсгөл 2019/5/7-2019/6/28, /ямар ажил/ 3. Эрдэнэ сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг зохиох ажил 2019/5/7-	1.Сайншанд суманд спорт талбайн ажил 1 дүгээр багц 2019/8/1-2019/9/10, 2.Замын Үүд суманд спорт талбайн ажил 1, 2 дугаар багц 2019/9/1-2019/11/10	1.Улаанбадрах суманд инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг 2019/5/25-2019/6/20, 2.Хатанбулаг худаг 2019/7/15-2019/8/10, 3. Хөвсгөл худаг 2019/6/20-2019/7/15, 4. Эрдэнэ худаг 2019/8/10-2019/8/30, 5. Шинэ хөдөө төсөл худаг 2019/8/1-2019/10/30

УТХО-аар 2019 онд гүйцэтгэсэн 25 ТАХ-ний гэрээний хугацааг сунгахдаа гүйцэтгэгч компаниас ирүүлсэн хүсэлтийн шалтгаан нөхцөлийг үнэлэхгүйгээр шийдвэрлэж, сунгалт хийсэн байна. Тухайлбал:

- Даланжаргалан сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж барих 2800,0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Илчит сансар ХХК нь 2019.06.01-2019.12.25-ны хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгч тендерт шалгарахдаа банкнаас 2000,0 сая төгрөгийн зээл авах боломжтой талаар тодорхойлолт гаргуулж тендерт шалгарсан байтал хөрөнгө дутагдсанаас шалтгаалан гэрээний хугацааг сунгуулах хүсэлт ирүүлж, 2020.07.01-ийг хүртэл хугацаанд сунгасан байна.
- Эрдэнэ суманд 80 ортой сургуулийн дотуур байр барих 1161,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2019.05.01-2019.08.20-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр ТӨБЭМ ХХК-тай УТ-НТШ-07/2019 тоот гэрээг байгуулсан байна. Гүйцэтгэгч компаниас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гэрээг 2 удаа сунгасан боловч хүсэлтэд сунгуулах шалтгаан, нөхцөл дурдаагүй байна.

Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссанаас хойш хугацаанд гүйцэтгэгч компаниас барилга, байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг албан тоотоор ирүүлсэн байхад захиалагч гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж алданги тооцоогүй байна.

- Эрдэнэ суманд баригдсан спорт талбайн ажлын гүйцэтгэгч Энх энэрлийн өргөө ХХК гэрээний хугацааг 7 хоногоор хэтрүүлсэн байхад захиалагч 826,1 мянган төгрөгийн алданги тооцоогүй.
- Хөвсгөл сумын ЭМТ-ийн өргөтгөлийн ажлыг гүйцэтгэгч Дорнын Очир далай ХХК гэрээний хугацааг 14 хоногоор хэтрүүлсэн байхад захиалагч 1282,3 мянган төгрөгийн алданги тооцоогүй байна.

Б.2.2. Мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан захиалагчийн хяналтыг чанартай, бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 5.2-т “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана” гэж заасан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4.1-т “Зохиогчийн хяналт гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр барилгын ажилд зохиогчийн хяналт тавих үүргийг хүлээнэ” гэж заасан.

Аймгийн Засаг дарга 33 ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр ГХБХБГ-тай гэрээ байгуулж, гэрээнд ерөнхий захиалагч нь барилгын захиалагчаас барилга угсралт, засварын ажлыг барилгын норм, дүрэм, зураг, төслийн дагуу чанартай гүйцэтгүүлэх, ажлын явцад гарсан дутагдал доголдлыг бүрэн засуулж, зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх, барилгын гүйцэтгэгчээс ирүүлсэн үе шатны ажлын гүйцэтгэлийг хянан, эцсийн шатанд баталгаажуулж, гүйцэтгэлийн дүгнэлт гарган, санхүүжүүлэх асуудлыг хариуцах, техник хяналтын ажлын тайлан шаардан гаргуулахаар заасан байна.

Мөн 30 ТАХ-д зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр 8 компанитай гэрээ байгуулжээ.

Гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд зохиогчид гэрээнд заасны дагуу ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлж хяналтын тайланд тусгасан байх боловч зарим ажлуудад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар тайлан, дүгнэлтэд тусгаагүй, захиалагч зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ авсан эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал:

- ✓ Даланжаргалан суманд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж барих ажилд зохиогчийн хяналт хийх 14/2019 тоот гэрээг Мон кузбасс ХХК-тай байгуулсан байна. Зохиогч гэрээний хугацаанд 2 удаа хяналт хийж, нийт 20 зөвлөмж өгсөн боловч хяналтын тайланд зөвлөмжүүдийг хэрхэн биелүүлсэн талаар тайланд тусгаагүй, хяналтын үр дүн тодорхойгүй байна.
- ✓ Хатанбулаг суманд төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж барих ажилд зохиогчийн хяналт хийх 08/2019 тоот гэрээг 2019.05.20-ны өдөр Мон кузбасс ХХК-тай байгуулсан байна. Зохиогч 2019.08.01-ний өдрийн хяналтаар 6 зөвлөмж өгч, 2019.09.07-ны хяналтаар бохир усны шугам, худаг угсрахдаа далд ажлын акт үйлдээгүй булсан, өмнөх зөрчил хэвээр гэсэн боловч зөвлөмжийг хэрхэн биелүүлсэн талаар тайланд тусгаагүй байна.
- ✓ Алтанширээ сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга байгууламж барих ажилд зохиогчийн хяналт хийх 24/2019 тоот гэрээг Мон кузбасс ХХК-тай байгуулсан байна. Зохиогч 2019.08.05-ны өдөр хийсэн хяналтаар бохир усны 1,7 км шугам, 50 орчим худаг угсрахдаа туршилт болон далд ажлын акт үйлдээгүй булсан зэрэг зөрчилд 4 зөвлөмж өгсөн боловч дараагийн шатны хяналтын тайланд зөвлөмжийн биелэлт, акт үйлдээгүй далд ажлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл тусгаагүй байна.

МУ-ын Барилгын тухай хуульд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргээс гадна барилга байгууламжийг барих, тэдгээрийн шинэчлэл, их засварын ажлын чанар, барилгын материал, бүтээгдэхүүний чанар, барилга байгууламжийн зураг төсөл, түүний хэрэгжилт, инженер-геологийн судалгааны ажлын чанар, барилгын ажлын гүйцэтгэлийн чанар, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, барилга байгууламжийн төсөвт өртөг, үнэ бүрдэлд хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр заасан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас барилга байгууламжийн зураг, төсөлд хяналт хийж, дүгнэлтээр зураг, төсөлд тодорхой чиглэлүүдийг тусгаж, дахин хянуулахаар зөвлөсөн байхад хэрэгжүүлсэн эсэх нь тодорхой бус байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэмд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэхээр заасан байна.

Гэтэл ТАХ-г ашиглалтад оруулах комиссын хурлаар дутуу хийгдсэн болон хийх шаардлагатай ажлуудыг улсын комисст хүлээлгэж өгөхөд бүрэн дуусгасан байх талаар зөвлөмж өгч, гүйцэтгэгч компани зөвлөмжийн биелэлтийг бэлтгэн комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулсан байх боловч зөвлөмж бүрэн биелэгдсэн байдалд хяналт тавиагүйгээс гүйцэтгэл дутуу ажлуудыг ашиглалтад хүлээн авсан байна. Тухайлбал:

- ✓ Өгөөмөрөн шанд ХХК-ний гүйцэтгэсэн Сайншанд сумын 4 дүгээр багт 320 хүүхдийн сургуулийн барилга угсралтын 2699,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Өгөөмөрөн шанд ХХК гүйцэтгэж, 2019.10.16-ний өдрийн УКД-61/2019 тоот комиссын актаар хүлээн авсан боловч хяналтын камер, компьютерын тоо ширхэг төсөвт тусгаснаас дутуу хийгдсэн.
- ✓ Сайншанд суманд 2 төрлийн спорт талбай байгуулах ажлын 1 дүгээр багцын 73,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Буянт Ас ХХК гүйцэтгэж, 2019.11.28-ны өдөр УКД-79/2019 актаар хүлээж авсан боловч байгалийн чулууг бетонд шигтгэж суулгаагүй, хүүхдийн тоглох аюулгүй орчныг бүрдүүлэхэд анхаараагүй, нэг бүр нь 95,0 мянган төгрөгийн үнэтэй явган зам талбайн шонтой гэрэлтүүлэг төсөвт 11 байхаар тусгаснаас 2 дутуу, 1850,0 мянган төгрөгийн үнэтэй модон саравч, нийт 2040,0 мянган төгрөгийн ажлыг хийгээгүй.
- ✓ Сайншанд суманд 2 төрлийн спорт талбай байгуулах 2 дугаар багцын 168,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Дэлгэр баясах зам ХХК гүйцэтгэж, 2019.11.19-ний өдөр УКД-77/2019 актаар хүлээж авсан боловч нэг бүр нь 200,0 мянган төгрөгийн үнэтэй дүүжин савлуур 2, 160,0 мянган төгрөгийн үнэтэй хогийн сав 3 дутуу, нийт 880,0 мянган төгрөгийн зураг төсөвт тусгагдсан ажлыг хийгээгүй байна.

Дээрх ажлуудыг бүрэн гүйцэтгүүлэхээр албан шаардлага хүргүүллээ.

Аймгийн МХГ-т барилга техникийн хяналтын улсын байцаагч байхгүйгээс барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах комисст тус байгууллагыг төлөөлж эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч оролцсон байна.

Б 2.3. Шинэ хөдөө төслийн хүрээнд барилга, байгууламж барих төсөл арга хэмжээнд батлагдсан хөрөнгийн санхүүжилтийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Салбар сайдын багцын хүрээнд олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Д/д	ТЕЗ-ийн нэр	Эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо	Нийт төсөвт өртөг /сая.төгрөг/	/Хүснэгт№5/ Санхүүжүүлсэн дүн /сая.төгрөг/	
				2019 онд санхүүжих дүн /сая.төгрөг/	
1	ХНХСайд	2	3373.4	2373.4	1572.7
2	БХБСайд	9	18049.7	6668.9	7126.7
3	БСШУССайд	26	22577.4	13900.6	15817.9
4	ЗТХСайд	2	6452.3	2415.9	0
5	ХХААХҮСайд	5	1216.0	1216.0	1175.3
6	ЭМСайд	4	8712.4	2837.6	428.5
Дүн		48	60381.2	29412.4	26121.1

МУ-ын Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Гурван тулгуурт хөгжлийн бодлогод хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, хүнс экспортлогч орон болох хоёр дахь зорилтын хүрээнд Шинэ хөдөө төслийг бүсчилж хэрэгжүүлэх арга хэмжээ авахаар тусгасан байна.

МУ-ын 2019 оны Төсвийн тухай хуулийн XV.1.26-д Шинэ хөдөө - Дорноговь аймаг /Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан сум/-т барилга байгууламжийн 1000,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг ХХААХҮС-аас эрх шилжүүлэн гүйцэтгүүлэхээр тусгагдсан байна.

Гэтэл тус ТАХ-г орон нутаг 6 багцад хуваан хэрэгжүүлэхдээ зарим арга хэмжээ нь Шинэ хөдөө төслийн ХАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байр бий болгох, иргэдийг ажилтай орлоготой болгох, гэсэн гол зорилготой уялдаагүй, ТАХ-ний санхүүжилтээс 276,4 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

- 3 дугаар багцаар 8 ширхэг фургон автомашин нийлүүлэх 261,4 сая төгрөгийн өртөгтэй ажлыг ОТТО МИР ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Сайхандулаан, Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Мандах сумдад хүлээлгэн өгсөн байна.
- Шинэ хөдөө төслийн 5 дугаар багцаар 106,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ОТТО МИР ХХК-иар гүйцэтгүүлэхдээ 15,0 сая төгрөгийн, 10 ширхэг компьютер бэлтгэсэн байна.

Б.3. Захиалагч, зохиогчийн хяналтын үр дүнг баримтжуулах, тайлагнах байдал хангалтгүй, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Б.3.1. Захиалагч болон зохиогч үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг хянахгүйгээр зардлыг санхүүжүүлсэн байна.

Зохиогчийн хяналт хийх гэрээнд заасан үүргээ биелүүлсэн тухай бүр тайлан гаргаж өгөх замаар зохиогчийн хяналтын зардлыг бүрэн олгох ба хяналтыг гэрээнд тохиролцсон тооны гүйцэтгэлийн үр дүнг харгалзан нэгдсэн дүгнэлт болон зохиогчийн хяналт хийсэн талаарх аймгийн ГХБХБГ-ын дүгнэсэн актыг үндэслэн зардлыг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн ЗДТГ нь ГХБХБГ-аар 33 ТАХ-ний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, нийт ажлын төсөвт тусгагдсан захиалагчийн хяналтын зардлын 70 хувь 231,5 сая төгрөгийг олгож, 30 хувь 97,9 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна.

Захиалагчийн хяналтын зардлын зарцуулалтыг авч үзэхэд ГХБХБГазар нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардалд 77,3 сая төгрөгийг зарцуулж, байгууллагын хэрэгцээнд хөрөнгө худалдан авахад 154,2 сая төгрөгийг зарцуулжээ.

Аймгийн ЗДТГ нь 33 ТАХ-д захиалагчийн хяналт хэрэгжүүлэхээр нийт зардлын 30 хувь буюу 97,9 сая төгрөгийн санхүүжилтийг авсан боловч хяналт хэрэгжүүлээгүй байна.

Зохиогчийн хяналтыг 30 ТАХ-д хэрэгжүүлэх гэрээг 8 компанитай байгуулж, 157.1 сая төгрөгийн зардлыг олгосон боловч хяналт хэрэгжүүлсэн байдлыг авч үзэхэд хангалтгүй байна. Тухайлбал:

- ✓ Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтэд зураг, төсөвт өөрчлөлт орсон болон магадалшгүй ажлын зардлаас санхүүжүүлж нэмэлтээр хийгдсэн ажлуудын талаар тусгаагүй байна.
- ✓ Захиалагчаас ТАХ-ний үе шатны ажлуудад үйлдсэн актуудын хугацааг авч үзэхэд 2019.11.10-ны өдөр алслагдсан зайд байрлах Иххэт сумын ахмадын өргөөний барилга, Замын Үүд сумын цэцэрлэгийн барилга, Мандах сумын цэцэрлэгийн барилга, Айраг сумын Соёл, спортын ордон гэсэн 4 ажилд 1 өдөр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн акт үйлдэж баталгаажуулсан байна.

Захиалагч нь зохиогчийн хяналтын зардлын санхүүжилтийг олгохдоо гэрээнд тохиролцсон хяналт хэрэгжүүлсэн тоо, хяналтын бодит үр дүнг хянахгүйгээр гүйцэтгэлийг баталгаажуулж олгосон байна.

Зохиогчийн хяналтын дүгнэлтэд ажлын явцад зураг, төсөвт орсон өөрчлөлт, ТАХ-ний төсөвт тусгагдаагүй нэмэлтээр гүйцэтгэсэн ажлын талаар тусгаагүй байхад захиалагч магадалшгүй ажлыг баталгаажуулж, санхүүжилтийг олгосон байна. Тухайлбал:

- ✓ Иххэт сумын нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын зоорийн болон гадна инженерийн шугам сүлжээний засварын ажлыг Чандмань Илч ОНӨХХК гүйцэтгэж нэмэлтээр насос суурилуулах, 0,136 км ус дамжуулах яндан хоолой шинэчлэх, 40 ширхэг чиг өөрчлөгч тавих, 26 ширхэг хаалт тавих зэрэг ажлуудыг хийсэн байхад Хайдро дизайн ХХК зохиогчийн хяналтын дүгнэлтэд тусгаагүй.
- ✓ Иххэт сумын нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээвэр, гадна фасадын ажлыг БЭМЭС ХХК гүйцэтгэж нэмэлтээр 16 айлын орон сууцны урд хэсэгт 12 м² талбайд бетон цутгалт, орцны 97,2 м² талбай бүхий саравчны засвар, 731,45 м² гадна хананы будаг зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байх боловч Сант номуун ХХК зохиогчийн хяналтын дүгнэлтэд тусгаагүй.
- ✓ Замын Үүд сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын дотор халаалтын системийн ажлыг Чандмань бадрал ХХК гүйцэтгэхдээ халаалтын өгөх, буцах шугамыг шалан доогуур сувагт угсрахаар зураг төсөлд тусгасныг 1 дүгээр давхрын шалан дээр ил угсарсан зөрчилд шугам хоолойг далдлах ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн боловч энэ талаар Сант номуун ХХК зохиогчийн хяналтын дүгнэлтэд тусгаагүй.
- ✓ Сайншанд сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын гадна дулаан, цэвэр усны шугам сүлжээ, дээврийн засварын ажлын зохиогчийн хяналтыг Сант номуун ХХК хэрэгжүүлж дүгнэлт гаргасан боловч акт огноогүй, төсөвт тусгагдаагүй нэмэлтээр бүргэд хаалга суулгах, чулуун шал хийх ажлуудыг гүйцэтгэж, магадалшгүй ажлын зардлаас санхүүжүүлсэн байхад хяналтын дүгнэлтэд зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн гэж дүгнэсэн байна.
- ✓ Сайншанд сумын 3 дугаар багт баригдсан кинотеатрын барилга барих ажлын тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажлын гүйцэтгэгч Южинтек өү юү жи ХХК нь зохиогч ЭГЭ ХХК-тай зөвшилцөн танхимын таазны зураг, дууны акустикийн чанартай холбоотой таазыг өөрчлөх, танхимын хэмжээнээс шалтгаалж суудлын тоог өөрчилсөн байх боловч зураг, төсөвт өөрчлөлт орсон талаар зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтэд дурдаагүй орхигдуулсан байна.

Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн Сайншанд-Замын Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18,25 км

хатуу хучилттай авто зам, Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамаас Ханбаянзүрх чиглэлийн хатуу хучилттай 6,85 км авто зам барих ажлуудын гүйцэтгэлийг ЗТХСайд хянан санхүүжилтийг гүйцэтгэгч компанид шилжүүлж, захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ хэрэгжүүлэн ажилласан байна.

Ажлын үе шатны хяналтыг захиалагчаас 2-6 удаа хэрэгжүүлж, 9-21 зөвлөмжийг өгсөн байх боловч аймгийн ГХБХБГ-ын хяналтын инженер нь замын мэргэжлээр мэргэшээгүй тул хяналт чанартай хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна.

2019 онд аймгийн хэмжээнд УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д ГХБХБГ-ын 4 мэргэжилтэн, гэрээт ажилтнууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 30 ТАХ-д 8 компани зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Зураг төсөв зохиогч 7 компани нь Улаанбаатар хотод тогтмол үйл ажиллагаа явуулдаг, мөн орон нутагт үйл ажиллагаа эрхлэгч Сант номуун ХХК нь нийт зураг төсвийн 40 хувь буюу 12 ТАХ-д зохиогчийн хяналтыг зэрэг хэрэгжүүлснээс ТАХ-дэд гэрээнд заасны дагуу хяналтыг хугацаанд нь тухай бүр хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ГХБХБГ нь 2019 онд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, тус албаны 2 мэргэжилтэн, гэрээт 2 инженер, нийт 4 ажилтан орон нутагт УТХО, ОНТХО, ОНХС, бусад эх үүсвэрээр хийгдсэн 100 хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байгаа нь ажиллах хүчний тоо, ажлын хэмжээ, цаг хугацаа, орон зайны хувьд захиалагчийн хяналтыг чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Б.3.2. Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна.

Аудитад хамрагдсан 6954.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 42 ТАХ-ний гүйцэтгэлийг авч үзэхэд дараах ажлуудын санхүүжилтийг бодит гүйцэтгэлийг хянахгүйгээр санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- ✓ Замын Үүд суманд 2 төрлийн спорт талбай байгуулах 1, 2 дугаар багцын ажлыг гүйцэтгүүлэхээр Буянт Ас ХХК-тай байгуулсан гэрээнд захиалагч тал нь гэрээт ажлын 40 хувийн санхүүжилтийг гүйцэтгэгчийн гаргаж ирүүлсэн гүйцэтгэлийг үндэслэн Сангийн яаманд уламжилж, үлдэгдэл санхүүжилтийг ажлыг бүрэн хийж дууссаны дараа хүлээн авч, актаар баталгаажуулан, гүйцэтгэгчийн ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийн дагуу олгоно гэж заасан байхад ажлыг бүрэн гүйцэтгээгүй, акт үйлдэж санхүүжилтийг бүрэн авч, барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.
- ✓ Сайншанд сумын 2 дугаар багт баригдах 1000 хүний суудалтай Соёл, спортын цогцолборын барилга угсралтын 5863,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд зохиогчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг BALDANS ХХК-тай байгуулж, зохиогчийн хяналтаар 120 мм-ийн тоосгон ханыг тоосгоор бус угсармал хавтангаар өөрчилсөн, захиалагчийн хүсэлтээр гадна фасадын өнгөлгөө, шалны материалыг өөрчлөх, дотор ханын өнгөлгөө, багануудын засварыг сайжруулах зэрэг ажлуудыг нэмэлтээр хийсэн байх боловч төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.

Аудитын явцад барилгын ажлын явцтай 2020.04.09-ний өдөр танилцахад шалны ажлыг эхлүүлсэн, гадна фасад, салхивчийн ажил бүрэн дуусаагүй байхад гүйцэтгэгч Болор аграмба ХХК-аас 2020.03.30-ны өдөр барилга, байгууламжийн ажлыг ашиглалтад өгөх улсын комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн байх тул захиалагчаар ажлын бодит гүйцэтгэлийг гаргуулж, ажил

- хүлээлгэж өгсөн хугацаагаар гэрээний алданги тооцуулахаар албан шаардлага хүргүүллээ.
- ✓ Улаанбадрах суманд 200 хүний суудалтай соёл, спортын ордны барилга барих 1089,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Тэгш өргөө ХХК 2019.06.18-2019.12.25-ны хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2020.03.15-ыг хүртэл сунгасан байна. Гүйцэтгэгч компаниас 2020.02.28-ны өдөр барилга, байгууламжийн ажлыг ашиглалтад өгөх улсын комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн боловч ажил өнөөдрийг хүртэл хугацаанд бүрэн дуусаагүй тул захиалагчаар ажлын бодит гүйцэтгэлийг гаргуулж, ажил хүлээлгэж өгсөн хугацаагаар гэрээний алданги тооцуулахаар албан шаардлага хүргүүллээ.
 - ✓ Мандах сумын Соёлын төвийн их засварын 134,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхээр Мөнх хялмаа ХХК-тай гэрээг 2019.05.15-ны өдөр байгуулсан байх ба гэрээний үүргээ биелүүлээгүй шалтгаанаар хийсэн ажлын гүйцэтгэлээр 50,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, аймгийн Засаг даргын 2019.11.05-ны А/824 захирамжаар гэрээг цуцалсан байна. Тус ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр 2019.11.15-ны өдөр Тольт дэнлүү ХХК-тай гэрээ байгуулахдаа өмнө хийсэн гэрээний дүнгээс гүйцэтгэгчийн авсан санхүүжилтийг хасаж 83,5 сая төгрөгийн гэрээ байгуулах байтал 89,3 сая төгрөгийн гэрээ байгуулан, 2019.12.17-ны өдрийн УКД-89/2019 актаар ажлыг хүлээж авсан боловч ажил дутуу, чанаргүй хийгдсэн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
 - ✓ Хөвсгөл сумын ЭМТ-ийн барилгын өргөтгөлийн ажлыг Дорнын очир далай ХХК гүйцэтгэж зураг төсөвт тусгагдаагүй өргөтгөлийг халаах шинэ халаалтын тогоо суурилуулсан зардал 2720672 төгрөгийг магадалшгүй ажлын зардлаас гаргаж санхүүжүүлсэн боловч халаалтын систем ажиллаагүйгээс өргөтгөлийг ашиглаагүй, гүйцэтгэгч шинэ тогоо суурилуулаагүй зөрчилд зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
 - ✓ Эрдэнэ суманд спорт талбай байгуулах 118,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Их энэрлийн өргөө ХХК 2019.07.17-2019.08.20-ны хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгч компаниас гэрээг 2019.10.25-ыг хүртэл сунгаж, улсын комисс ажиллуулахаар 2019.11.01-ний өдөр 01/50 дугаартай албан бичиг ирүүлсэн байхад хугацаа хэтрүүлсэн хоногт ногдох 826,136 төгрөгийн алданги тооцоогүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Б.3.3. Аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА нь хуульд заасан дотоод хяналт хийх чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

МУ-ын Төсвийн тухай хуульд Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулахаар заасан байна.

СХАА-ны аймгийн Засаг даргаар батлуулсан 2019 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд УТХО-аар хийгдсэн ажлын үр дүнд хийх хяналт шалгалт тусгагдаагүй, УТХО-аар хийгдсэн ажлын үр дүнд хяналт шалгалт хийгээгүй, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоогүй байна.

Б.4.1. Засгийн газар, ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилт, үр дүнг тооцсон уу.

Төсвийн тухай хуульд 2019 онд 34 ТАХ-г бүрэн хэрэгжүүлж дуусгахаар тусгагдсан байна. Үүнээс Шинэ хөдөө төслөөр хэрэгжүүлэх мал угаалгын ванн хийх ажил, Алтанширээ суманд цэцэрлэгийн барилга барих ажлуудыг төлөвлөгдсөн хугацаанд хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг сунгасан байна.

Харин Сайншанд, Замын Үүд сумдад спорт талбай байгуулах, Мандах сумын Соёлын төвийн барилгын их засвар, Иххэт суманд ахмадын өргөө барих ажлуудыг 2019 онд ашиглалтад оруулах комиссоор хүлээлгэн өгсөн боловч ажил бүрэн хийгдэж дуусаагүйгээс хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх үр дүн бүрэн хэрэгжээгүй байна.

Б.4.2 Зарим ТАХ-ний тухайн жилд батлагдсан санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэхгүй олгосон байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журамд СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн хянаж баталгаажуулсан гарын үсэг бүхий албан тоот, холбогдох материалыг шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг хянаж санхүүжилтийг олгохоор заасан байна.

- ✓ Алтанширээ сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга, байгууламж барих ажил гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэгчийн гаргаж ирүүлсэн гүйцэтгэлийг баталгаажуулан 2019 онд 1000,0 сая төгрөгийг олгож, үлдэгдэл санхүүжилтийг ажлыг гүйцэтгэж актаар баталгаажуулан хүлээн авсны дараа гүйцэтгэгчийн ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлээр 2020 онд санхүүжилтийг олгохоор заасан байхад 2019.12.30-ны өдөр Сангийн яамнаас гүйцэтгэлд үндэслэхгүйгээр 1000,0 сая төгрөгийг олгуулахаар шилжүүлж, тайлант хугацаанд нийт 2000,0 сая төгрөгийг олгосон байна.
- ✓ Сайншанд сумын 2 дугаар багт 1000 хүний суудалтай Соёл спортын цогцолборын барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Болор аграмба ХХК-тай байгуулсан гэрээнд болон Төсвийн тухай хуулиар 2019 онд нийт санхүүжилтээс 3300,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байхад 2019.12.26-ны өдөр Сангийн яамнаас гүйцэтгэлд үндэслэхгүй санхүүжилт 2036,9 сая төгрөгийг шилжүүлж, тайлант онд нийт 5345,2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Алтанширээ суманд 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих 785,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг РСТ ХХК-тай байгуулсан УТ-НТШ-08/2019 тоот гэрээнд захиалагч тал нь гэрээт ажлын 40 хувийг гүйцэтгэсний дараа гүйцэтгэгчийн гаргаж ирүүлсэн гүйцэтгэлийг үндэслэн эхний санхүүжилтийг, явцын санхүүжилтийг 40 хувийн гүйцэтгэлээр Сангийн яаманд уламжлан санхүүжилтийг олгож, үлдэгдэл 20 хувийн санхүүжилтийг ажлыг бүрэн хийж дууссаны дараа хүлээн авч, актаар баталгаажуулан гүйцэтгэгчийн ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийн дагуу олгохоор заасан байхад МУ-ын ЗГ-ын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа байршуулан, гэрээг 2020.07.01-нийг хүртэл хугацаанд сунгаж, санхүүжилтийг 100 хувь олгосон байна.

Сангийн яам захиалагчаас баталгаажуулсан гүйцэтгэлд үндэслэхгүй, 2019 оны Төсвийн тухай хуульд олгохоор тусгагдсанаас илүү дүнгээр зарим ТАХ-г санхүүжүүлж Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

Б 4.3. 2019 онд ашиглалтад орсон 1057,6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаагүй байна.

МУ-ын Барилгын тухай хуулийн 35.1.4 “Аймгийн Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Гэтэл 2019 онд хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагууд данс бүртгэлд тусгаж аваагүй байна. Тухайлбал:

- ✓ Замын Үүд суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга худалдан авах 962,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Гантулга трейд ХХК гүйцэтгэж, 2019.04.29-ний өдөр барилгыг захиалагч хүлээн авсан боловч ашиглагч байгууллага 40,9 сая төгрөгийн эд хогшлыг барилга байгууламжийн дансанд нийт дүнгээр бүртгэсэн байна.
- ✓ Сайншанд суманд 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга худалдан авах 960,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Гантулга трейд ХХК гүйцэтгэж, 2018.11.29-ний өдөр барилгыг захиалагч хүлээн авсан боловч ашиглагч байгууллага тус хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ төсөвт тусгагдсан 22,9 сая төгрөгийн эд хогшлыг барилга байгууламжийн дансанд нийт дүнгээр бүртгэсэн байна.
- ✓ Эрдэнэ суманд 52,0 сая төгрөгийн өртөгтэй, 2 ширхэг инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг барих ажлыг Эхний эхэн ХХК гүйцэтгэж, 2019.11.16-ний өдөр ашиглалтад хүлээлгэж өгсөн байхад нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.
- ✓ Хөвсгөл суманд 52,0 сая төгрөгийн өртөгтэй, 2 ширхэг инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг барих ажлыг Эхний эхэн ХХК гүйцэтгэж, 2019.11.14-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн байхад нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.
- ✓ Иххэт сумын нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын зоорийн болон гадна инженерийн шугам сүлжээний засварын 889,8 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Чандмань Илч ОНӨХХК гүйцэтгэж, ашиглалтад 2018.10.25-д хүлээлгэж өгсөн байхад бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх ТАХ-үүдийг данс бүртгэлд бүрэн тусгуулахаар албан шаардлага хүргүүллээ.

УТХО-аар хэрэгжүүлж ашиглалтад оруулсан ТАХ-г ашиглагч байгууллага өнөөдрийг хүртэл данс бүртгэлд тусгаагүй, захиалагч байгууллагаас ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах үүргээ хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, ашиглалт, хамгаалалтын асуудал орхигдохоор байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө нийгмийн болон тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлээгүй, зураг төслийг батлуулаагүй, барилга барих газар болон инженерийн шугам сүлжээний асуудлыг шийдвэрлээгүй, үр ашигтай нь техник эдийн засгийн үндэслэлээр тогтоогдоогүй, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллын талаар тооцоо судалгаа хийгдээгүй ажлуудыг тусгаж төлөвлөсөн байна.
- Аймгийн хэмжээнд хот байгуулалтын архитекторын асуудал хариуцсан мэргэжлийн боловсон хүчин байхгүй байгаагаас шалтгаалж ТАХ-ний ажлын даалгавар, архитектор төлөвлөлтийг тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлага, хот төлөвлөлттэй уялдуулж зураг төсөвт тусгуулах ажил чанаргүй хийгдэх нөхцөл үүссэн байна.
- ТАХ-ний зураг, төсвийг магадлалаар баталгаажуулах ажил хангалтгүй хийгдсэнээс зураг, төсөвт өөрчлөлт орох, төлөвлөөгүй ажлууд нэмэлтээр хийгдэж, ажил гүйцэтгэх хугацаанд нөлөөлсөн байна.
- МУ-ын 2019 оны Төсвийн тухай хуулиар 2020 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, санхүүжилтийг олгохоор баталсан ТАХ-үүдийг орон нутаг тухайн онд дуусгах гэрээ байгуулан гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан боловч зарим ажил бүрэн хийгдээгүй байна.
- Үнэлгээний хороо 2019 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан хугацаа, санхүүжилт, ТАХ-ний онцлогийг харгалзаж ТББ-ийг боловсруулаагүйгээс зарим талаар оролцогчдын өрсөлдөх боломжийг хязгаарласан, ТАХ-ний хэрэгжих хугацаа хойшилсон, гэрээний тусгай нөхцөлд тусгасан зарим заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.
- Үнэлгээний хороонд Төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг хуульд заасан тоогоор бүрэн хамруулаагүй байна.
- Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан захиалагчийн хяналтыг чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй нь УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний чанар байдалд нөлөөлсөн байна.
- Захиалагч, зохиогчийн хяналтын үр дүнг баримтжуулах, тайлагнах байдал хангалтгүй, захиалагчийн хяналтын зардлыг хяналт хэрэгжүүлэхээс бусад зардалд зарцуулсан байна.
- Шинэ хөдөө төслийн хүрээнд барилга, байгууламж барих төсөл арга хэмжээнд тусгагдсан 1,0 тэрбум төгрөгийн төсөвтэй ажлыг хэрэгжүүлэхдээ 276,4 сая төгрөгийн автомашин, компьютер бэлтгэж, төслийн зорилготой уялдуулахгүй зориулалт бусаар зарцуулсан байна.

- УТХО-аар хийгдсэн ТАХ-ний үр дүнд аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын алба хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт гаргаж ажиллаагүйгээс хөрөнгө оруулалтад тавих дотоод аудитын хяналт орхигдсон байна.
- БСШУСС, БХБС-ын багцаас эрх шилжиж ирсэн 2 ажлын санхүүжилтийг 2019 оны Төсвийн тухай хуульд зааснаас илүү олгосон байна.
- УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-г данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.
- ТАХ-г хэрэгжүүлэгч гүйцэтгэгч компаниудын гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, хариуцлага тооцох ажил орхигдсон, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг бодитой тооцож хянаагүйгээс зарим ажлуудыг зураг төсөвт тусгасны дагуу бүрэн хийгээгүй, ажил хүлээлцэх улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар бүрэн биелэгдээгүй байна.
- Дорноговь аймагт сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалтын ажил эрчимтэй хийгдэж, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ 8,2 дахин өссөнтэй холбоотой ажлын ачаалал нэмэгдэж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, эрэмбэлэх ажил орхигдон, ХО-ын асуудал хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэлийг хянаж, санхүүжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.
- Өмнө онуудад УТХО-ын үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орон нутгийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан, зураг төсөв батлагдсан, эдийн засгийн үндэслэл хийгдсэн ТАХ-г тусгуулах зөвлөмжийг жил бүр өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдсан байна.

Аудитаар нийт 5943,1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, илүү олгосон магадлашгүй ажлын зардал төлүүлэх, гэрээний алданги тооцох, ажил дуусгуулах, гэрээ дүгнэж алданги тооцуулах, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх, гэрээний тусгай нөхцөлд тусгасан заалтын хэрэгжилтийг хангуулах тухай 1062,4 сая төгрөгийн 6 албан шаардлага бичиж, 4880,7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. МУ-ын Барилгын тухай хуульд заасан “Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулах талаар Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал уламжилж өгөх.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т.ЭНХТҮВШИН ТАНАА:

1. УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хөрөнгө оруулалтын суурь судалгаанд үндэслэн, ТАХ-г тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх, зураг төслийг батлагдсан, ТЭЗҮ хийгдсэн, бусад зөвшөөрөл олгогдсон, хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллын талаар тооцоо судалгаа хийгдсэн ажлуудыг төлөвлөх.

2. Дараа онд шилжин хийгдэхээр батлагдсан ТАХ-г хуульд заасан хугацаагаар гэрээ байгуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэх боломжийг бүрдүүлэх.

3. Төсвийн тухай хуульд тусгагдсан ТАХ-ний санхүүжилтийг төслийн зорилготой уялдуулж, батлагдсан ангиллын дагуу зориулалтаар зарцуулах.

4. Батлагдсан санхүүжилтийг Төсвийн тухай хууль болон ТАХ-ны бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгох.

5. Гүйцэтгэгч компаниудын гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, хариуцлага тооцож ажиллах

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА Б.ГАНЗОРИГ ТАНАА:

1. Захиалагчийн хяналтын зардлыг журмын дагуу хяналт хэрэгжүүлэхэд зарцуулах.

2. Аймгийн ЗДТГ-ын ХБТХ-ийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ТАХ-ний төлөвлөлтийн чиг үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.

3. Хэрэгжүүлэх ТАХ-ний гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд тусгасан заалтуудын хэрэгжилтийг хангуулах талаар хяналт тавьж ажиллах.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН ТАНАА:

1. Захиалагч, зохиогчийн хяналт хийх гэрээнд тусгагдсан үр дүнг баримтжуулах, тайлагнах тухай заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Захиалагчийн хяналтын зардлыг журмын дагуу хяналт хэрэгжүүлэхэд болон хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах, хот байгуулалтын архитекторын асуудал хариуцсан мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж сургах.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБАНЫ ДАРГА У.БАЯРБИЛЭГ ТАНАА:

1. ТАХ-ний онцлогийг харгалзаж, ижил төстэй ажлуудын ТББ-т тусгагдсан шалгуурыг адил боловсруулах зарчмыг баримтлан, тендер шалгаруулалтад оролцогчдод тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлэх байдлаар ТББ-ийг боловсруулах.

2. Үнэлгээний хороонд төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг хуульд заасан тоогоор бүрэн хамруулах.

3. ХАА-г цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх, тендер шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn

2020.05.05 № 3/468
танай 2020.05.04 -ны № 1-6/467 -т

Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2020 оны төлөвлөгөөний дагуу хийгдсэн “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд дараах саналыг оруулж байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд мэргэжлийн архитекторч албан тушаалтан байхгүй учир хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтуудыг аймгийн ГХБХБГ-аар гүйцэтгүүлж байна.
2. Улсын төсвөөр батлагдсан зарим ажлууд нь олон жилийн өмнө хийгдсэн зураг, төсөвтэй байдаг учир тухайн ажлын худалдан авах ажиллагааг зарлахад зураг, төсвийг зайлшгүй өөрчлөх шаардлагатай болдог. Үүнээс үүдэн зарим ажлын хувьд зураг, төсвийг дараа нь батлуулж байна гэдэг асуудал гарч байна.
3. Эрдэнэ суманд спорт тоглоом байгуулах ажлын гүйцэтгэгч “Энх энэрлийн өргөө” ХХК-ийн ирүүлсэн хүсэлт болон улсын комисс хэзээ ажилласан талаарх мэдээллийг аймгийн ГХБХБГ-аас хүргүүлнэ.
4. Аймгийн Аудитын газраас 2019 оны 12 дугаар сард хийсэн явцын хяналт шалгалтын дагуу Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгч “Дорнын очир далай” ХХК-ийн санхүүжилтээс 961704 төгрөгийн алданги болон зохиогчийн хяналтын зардлын 1360336 төгрөгийг тус тус хасч тооцсон тул одоо алданги тооцох үндэслэлгүй болно.
5. Шинэ хөдөө төслийн хүрээнд батлагдсан 1.0 тэрбум төгрөгийг 6 багц ажил болгон зарлахдаа Улсын их хурлын гишүүн болон тойргийн 8 сумын Засаг дарга нарын саналыг авч хэрэгжүүлсэн болно.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ

**ДОРНОГОВЬ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Амгийн ЗДТГ-ын байр 104 тоот,

Утас/факс: (705) 2-00-04

2020.0506 № 185.

танай _____-ны № _____-т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

**Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай**

Танай байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдажийн дагуу хийгдсэн “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд дараах саналыг оруулж байна. Үүнд:

Б.1.3: Манай газраас тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, тендерийн жишиг баримт бичгийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулан зарлан нийтэлдэг.

ТББ-ийн тусгай нөхцөлд ажиллах хүчний тоог тодорхой дурдаагүй: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, тендерийн жишиг баримт бичгийн тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадвар /гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар туршлагын талаарх мэдээлэл/ ирүүлэхээр заасны дагуу ТББ-ийг боловсруулсан болно.

ТББ-т заасан дотоодын давуу эрх тооцох шалгуурыг хангаж шалгарсан ААН нь аймгийн ХХҮГ-тай ажиллах хүч аваагүй, захиалагч гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй: ХХҮГ-ийн гэрээний биелэлтийг гарган, гэрээний биелэлтийг ханган ажиллахаар гэрээнд тусгаж ирүүлсэн болно. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журмын 3.4-д Төсвийн ерөнхийлөн захирагч нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтийн явцын талаарх дараах мэдээллийг Мэргэжлийн байгууллагад улирал бүрийн дараа сарын эхний ажлын 10 өдөрт багтаан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. 5.4-д мэргэжлийн байгууллага энэхүү журмын 3.4-т заасан гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллана гэж заасан болно.


ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлд “Гүйцэтгэгч нь ажлыг өөрийн хөрөнгөөр бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгсний дараа санхүүжилтийг олгоно” гэж заасан нь оролцогчийн оролцоог хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн байна: ТББ-ийн ТШӨХ-ийн ТӨӨЗ-д “Гүйцэтгэгч нь ажлыг өөрийн хөрөнгөөр бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгсний дараа санхүүжилтийг олгоно” гэж заасан нь түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл түүнтэй адилтгах хөрөнгийн эх үүсвэртэй байх шаардлагатай дүйцэхүйц тухайн заалтыг ТББ-т тусгасан нь оролцогчийн оролцоог хязгаарлах нөхцөлийг бүрдүүлээгүй болно.

МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.1-т Захиалагч тендерийн урилгыг үндэсний МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.1-т Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасан байхад 11 ТАХ-ний тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтлээгүй: Тухайн 11 ТАХ-ний

8 нь төсөвт өртгийн босго үнээр харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан. Харьцуулалтын аргаар зарласан ТАХ-ний урилгыг өдөр тутамын сонин хэвлэлд нийтлэхгүй болно. 2 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын урилгыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад заасны дагуу тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасны дагуу “Монголын мэдээ” сонинд нийтлүүлэхээр өгсөн. “Монголын мэдээ” өдөр тутмын хэвлэлийн газар нь халдварт өвчний улмаас үйл ажиллагаа нь түр саатсан тул хэвлэгдэж ирээгүй 2 ТАХ-ний урилгыг ирүүлээгүй болно. Тухайн урилгыг шүүж, нөхөн ирүүлэхээр мэдэгдсэн. Урилга нийтлүүлэхээр илгээсэн холбогдох тайлбарыг танай газарт хүргүүлсэн.

Б.1.4: Тендерт оролцож байгаа оролцогч компаниудын ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг хязгаарласан байна: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудсаар /www.tender.gov.mn/ худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулж, гарсан үр дүнг тухай бүрд нь нээлттэй ил тод байдлыг ханган тогтмол байршуулан ажилласан. Үнэлгээний хорооны гишүүд тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам, ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдлөг болгон ажилласан болно.

ДАРГА



У.БАЯРБИЛЭГ



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Утас: 7052 3998, И-мэйл: dornogovi@gazar.gov.mn


2020.05.06 № 404
танай 2020.05.04-ны № 1-6/408 -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА


Танай байгууллагаас ирүүлсэн “Улсын төсвийн
2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт,
үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Тус аудиттай холбоотой санал байхгүй болно.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.БАЯРМАА



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн саналд:

1. Хот байгуулалтын архитекторын асуудал хариуцсан мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж сургах талаар зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэхээр тайланд өөрчилж тусгалаа.
2. Энэ асуудлыг Төсвийн тухай хуульд тодорхой заасан тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
3. Энх энэрлийн өргөө ХХК-ний гүйцэтгэсэн Эрдэнэ суманд спорт талбай байгуулах ажилд гэрээний алданги тооцох зөрчил нь баримтаар нотлогдсон, захиалагч байгууллагын холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулсан тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
4. Дорнын Очир далай ХХК-ний гүйцэтгэсэн Хөвсгөл сумын ЭМТ-ийн барилгын өргөтгөлийн ажилд гэрээний алданги тооцох зөрчил нь баримтаар нотлогдсон, захиалагч байгууллагын холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулсан тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
5. Шинэ хөдөө төслийн хүрээнд барилга байгууламж барихаар батлагдсан төсвийг төслийн зорилготой уялдуулаагүй зарцуулсан байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Орон нутгийн өмчийн албанаас ирүүлсэн саналд:

1. Б.1.3-т ТББ-ийн тусгай нөхцөлд ажиллах хүчний тоог дурдаагүй талаарх асуудлыг тайланд хасаж, 11 ТАХ-ний тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтлүүлээгүй гэсэн хэсэгт 4 ТАХ-нийх болгож өөрчилж тусгалаа.
2. Ирүүлсэн бусад санал нь холбогдох хууль, журамд тусгагдсан, баримтаар нотлогдож байх тул аудитын тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/17

Дорноговь аймаг, Сайншанд сум


Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 тоот тушаал, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40 дэх заалт, 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "ТАБ-ын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагуудыг хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ-ын дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, ГХБХБГ, аймгийн ЗДТГ, ОНӨГ-ын дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
5. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



1

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020
оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/,,,,,,
тоот тушаалын хавсралт

4417144353
E:OAO056 9025707

“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”
сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн
албан шаардлагын жагсаалт

Д/д	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын агуулга	Мөнгөн дүн /сая.төгрөг/	Хэрэгжүүлэх албан тушаалтан
1	01/93 ГАГ-2020/02-ГА	Ажил гүйцэтгүүлэх гэрээг дүгнэж, алданги тооцуулах тухай	0	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Ч.Түвшинтөр Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн А.Амгаланзаяа
2	02/94 ГАГ-2020/02-ГА	Хөрөнгө данс бүртгэлд тусгуулах тухай	1057,6	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Ч.Түвшинтөр Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн А.Амгаланзаяа
3	03/95 ГАГ-2020/02-ГА	Зөрчил арилгуулах тухай	0	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Ч.Түвшинтөр Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн А.Амгаланзаяа
4	04/96 ГАГ-2020/02-ГА	Ажил бүрэн дуусгуулах тухай	0	ГХБХБГ-ын дарга Ц.Оюунсайхан Ц.Баярмаа
5	05/97 ГАГ-2020/02-ГА	Зориулалт бусаар зарцуулсан магадлашгүй ажлын зардлыг төлүүлэх тухай	2,7	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Ч.Түвшинтөр Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн А.Амгаланзаяа
6	06/98 ГАГ-2020/02-ГА	Гэрээний алданги нөхөн тооцуулах тухай	2,1	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Ч.Түвшинтөр Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн А.Амгаланзаяа
Нийт дүн			1062,4	

-----000-----

ТАХ-г орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан байдал

№	Зорилт	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил
1	Нэг. Олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн бодлого	III.4.1.1	Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол, хамгаалалтын нэгдсэн систем /Дорноговь, Замын-Үүд сум/
2		VII.3.1.1	Гаалийн хорооны барилга худалдан авах /Дорноговь, Замын-Үүд сум/
3		XI.1.37	Боомтын талбайн гэрэлтүүлэг /Дорноговь, Хатанбулаг сум, Ханги боомт/
4		XI.1.78	Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга байгууламж /Дорноговь, Алтанширээ сум/
5		XI.1.81	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж /Дорноговь, Хатанбулаг сум/
6		XI.1.82	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам, сүлжээ, барилга байгууламж /Дорноговь, Даланжаргалан сум/
7		XI.2.2	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээвэр, гадна фасад, дулаалга, зоорийн болон гадна инженерийн шугам сүлжээний засвар /Дорноговь, Иххэт сум/
8		XI.4.2	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсөв /Дорноговь, Хатанбулаг сум/
9		XI.4.3	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсөв /Дорноговь, Хөвсгөл сум/
10		XI.4.4	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсөв /Дорноговь, Эрдэнэ сум/
11		XII.2.1.36	Кино театрын барилга /Дорноговь, Сайншанд сум/
12		XIII.1.1.2	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам /Дорноговь, Сайншанд сум/
13		XIII.1.1.56	Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замаас Ханбаянзүрх чиглэлийн хатуу хучилттай авто зам, 6.85 км /Дорноговь, Сайншанд сум/
14		XV.1.15	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг 2ш /Дорноговь, Улаанбадрах сум/
15		XV.1.16	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг, 2 ш /Дорноговь, Хатанбулаг сум/
16		XV.1.17	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг, 2 ш /Дорноговь, Хөвсгөл сум/
17		XV.1.18	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг, 2 ш /Дорноговь, Эрдэнэ сум/
18		XV.1.26	Шинэ хөдөө - Дорноговь төсөл /Дорноговь, Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан сум/
19		XVI.1.14	Дулааны станцын зуух, шугам сүлжээний шинэчлэлт /Дорноговь, Сайншанд сум/
20	Гурав. Хүн төвтэй нийгмийн бодлого	IX.1.1.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилга худалдан авах /Дорноговь, Сайншанд сум/
21		IX.1.1.5	Ахмадын өргөөний барилга /Дорноговь, Иххэт сум/
22		XI.1.15	Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга /Дорноговь, Замын-Үүд сум/
23		XII.1.1.25	Сургуулийн барилга, 320 суудал /Дорноговь, Сайншанд сум/
24		XII.1.1.111	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 100 ор /Дорноговь, Сайншанд сум/
25		XII.1.1.196	Дотуур байрын барилга, 80 ор /Дорноговь, Эрдэнэ сум/
26		XII.1.1.286	Цэцэрлэгийн барилга /Дорноговь, Алтанширээ сум/
27		XII.1.1.287	Цэцэрлэгийн барилга /Дорноговь, Замын-Үүд сум/
28		XII.1.1.297	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 100 ор /Дорноговь, Замын-Үүд сум/
29		XII.1.1.304	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дорноговь, Мандах сум/
30		XII.1.1.356	Цэцэрлэгийн барилгын дотор халаалтын систем /Дорноговь, Замын-Үүд сум, 2 дугаар цэцэрлэг/
31		XII.1.2.20	Сургуулийн барилгын их засвар /Дорноговь, Улаанбадрах сум/
32		XII.1.2.39	Сургуулийн дотуур байрын барилгын дээврийн засвар /Дорноговь, Улаанбадрах сум/
33		XII.1.2.46	Цэцэрлэгийн барилгын гадна дулаан цэвэр усны шугам сүлжээ, дээврийн засвар /Дорноговь, Сайншанд сум, 3 дугаар цэцэрлэг/
34		XII.1.2.48	Цэцэрлэгийн барилгын дотор сантехник, гадна бохир усны шугамын их засвар /Дорноговь, Замын-Үүд сум, 1 дүгээр цэцэрлэг/
35		XII.1.2.49	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар /Дорноговь, Сайншанд сум, 9 дүгээр цэцэрлэг/
36		XII.1.2.53	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дорноговь, Айраг сум/
37		XII.2.1.40	Соёл, спорт цогцолборын барилга, 1000 суудал /Дорноговь, Сайншанд сум/
38		XII.2.1.41	Соёл, спортын төвийн барилга /Дорноговь, Айраг сум/
39		XII.2.1.42	Соёл, спортын төвийн барилга, 200 суудал /Дорноговь, Улаанбадрах сум/
40		XII.2.1.43	Соёл, спортын төвийн барилга, 200 суудал /Дорноговь, Хөвсгөл сум/
41		XII.2.2.1	Соёлын төвийн барилгын их засвар /Дорноговь, Алтанширээ сум/
42		XII.2.2.5	Соёлын төвийн барилгын дээвэр, гадна дотор засвар /Дорноговь, Хатанбулаг сум/
43		XII.2.2.7	Соёлын төвийн барилгын их засвар /Дорноговь, Мандах сум/
44		XII.3.1.19	Спорт заалын барилга /Дорноговь, Өргөн сум/
45		XII.3.1.26	Спорт талбай /Дорноговь, Замын-Үүд сум/
46		XII.3.1.27	Спорт талбай /Дорноговь, Эрдэнэ сум/
47		XII.3.1.28	Спорт талбай, 2 ш /Дорноговь, Сайншанд сум/
48		XVII.1.7	Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ор /Дорноговь, Замын-Үүд сум/
49		XVII.1.8	Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд сум/
50		XVII.1.66	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Дорноговь, Алтанширээ сум/
51		XVII.1.67	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Дорноговь, Хөвсгөл сум/
52		XVII.2.13	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорноговь, Айраг сум/

МУ-ын Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш зураг, төсөв хийгдсэн
ТАХ-ний судалгаа

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Зураг	Төсөв /Хяналтын/	ТЭЗҮ
1	IX.1.1.5	Ахмадын өргөөний барилга /Дорноговь, Иххэт сум/	2019.02	2019.07.21	
2	XI.1.37	Боомтын талбайн гэрэлтүүлэг /Дорноговь, Хатанбулаг сум, Ханги боомт/	2019.03.06	2019.03.06	
3	XII.1.1.286	Цэцэрлэгийн барилга /Дорноговь, Алтанширээ сум/	2019.07.22	2019.06.24	
4	XII.1.1.287	Цэцэрлэгийн барилга /Дорноговь, Замын-Үүд сум/	2019.07.22	2019.06.21	
5	XII.1.1.304	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дорноговь, Мандах сум/	2019.06.13	2019.06.22	
6	XII.1.2.39	Сургуулийн дотуур байрын барилгын дээврийн засвар /Дорноговь, Улаанбадрах сум/	2019		
7	XII.1.2.46	Цэцэрлэгийн барилгын гадна дулаан цэвэр усны шугам сүлжээ, дээврийн засвар /Дорноговь, Сайншанд сум, 3 дугаар цэцэрлэг/	2019.05	2019.03.16	
8	XII.1.2.48	Цэцэрлэгийн барилгын дотор сантехник, гадна бохир усны шугамын их засвар /Дорноговь, Замын-Үүд сум, 1 дүгээр цэцэрлэг/	2019		
9	XII.1.2.53	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дорноговь, Айраг сум/	2019.05	2019.06.21	
10	XII.2.1.36	Кино театрын барилга /Дорноговь, Сайншанд сум/	2019.02		
11	XII.2.1.40	Соёл, спорт цогцолборын барилга, 1000 суудал /Дорноговь, Сайншанд сум/	2019.01.02	2019	
12	XII.2.1.41	Соёл, спортын төвийн барилга /Дорноговь, Айраг сум/	2019.04.01	2019.05.06	
13	XII.2.1.43	Соёл, спортын төвийн барилга, 200 суудал /Дорноговь, Хөвсгөл сум/	2019		
14	XII.2.2.5	Соёлын төвийн барилгын дээвэр, гадна дотор засвар /Дорноговь, Хатанбулаг сум/	2019	2019.03.16	
15	XII.3.1.19	Спорт заалын барилга /Дорноговь, Өргөн сум/	2019	2019.06.12	
16	XII.3.1.26	Спорт талбай /Дорноговь, Замын-Үүд сум/	2019	2019.04	
17	XII.3.1.27	Спорт талбай /Дорноговь, Эрдэнэ сум/	2019.08	2019.04.05	
18	XII.3.1.28	Спорт талбай, 2 ш /Дорноговь, Сайншанд сум/	2019.03.11	2019.05.21	
19	XV.1.15	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг 2ш /Дорноговь, Улаанбадрах сум/		2019	
20	XV.1.16	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг, 2 ш /Дорноговь, Хатанбулаг сум/		2019	
21	XV.1.17	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг, 2 ш /Дорноговь, Хөвсгөл сум/		2019	
22	XV.1.18	Инженерийн хийцтэй бэлчээрийн гүний худаг, 2 ш /Дорноговь, Эрдэнэ сум/		2019	
23	XVII.1.66	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Дорноговь, Алтанширээ сум/	2019.03.26	2019.04.10	
24	XVII.1.67	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Дорноговь, Хөвсгөл сум/	2019.01	2019	
25	XVII.2.13	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорноговь, Айраг сум/		2019.02.23	

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:	Л.Равдандорж

ХЯНАСАН:

Аудитын менежер:	Ч.Хэрлэнчимэг
Дарга, тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ.**